

# Ур чадварын дадлагажигч танд

「Ур чадварын дадлагажигч нарт зориулсан гарын авлага」 аппликейшныг татаж авна уу!  
Японд хараахан ирээгүй байгаа дадлагажигч нар ч татан авч ашиглах боломжтой боллоо !

Энэхүү апп нь ур чадварын дадлагажигч та бүхнийг хилээр орж ирэх үед өгсөн 「Ур чадварын дадлагажигч нарт зориулсан гарын авлага」 -ыг хэзээ ч хаанаас ч харж болох ухаалаг утсанд зориулагдсан апп болно.

Ур чадварын дадлагажилттай холбоотой шинэ хууль журам болон өдөр тутмын аж амьдралд тань хэрэг болох мэдээ мэдээлэл, гамшгийн тухай мэдээлэл, хууль журмын зөрчил болон түүнийг мэдүүлэх аргачлал болон бэрхшээл тохиолдсон үедээ зөвлөгөө авах зэрэг хэрэгцээтэй мэдээллээр бүрэн хангагдсан танд зайлшгүй шаардлагатай апп юм.

Одоо шууд эндээс татаж авах →

■ Японоос бусад оронд худалдан авсан төхөөрөмж болон гар утсанд ч ашиглаж болох боллоо !

Мөн японоос өөр улсаас татан авах боломжтой боллоо

Японд хараахан ирээгүй байгаа дадлагажигч нар ч ашиглаж болно

■ 9 орны хэлээр ашиглах боломжтой

Вьетнам, Хятад, Филиппин, Индонези, Тайланд, Мянмар, Монгол, Камбож болон Англи хэл



「Ур чадварын дадлагажигч нарт зориулсан гарын авлага」 нь таньд шаардлагатай мэдээллээр бүрэн хангагдсан

- Японы гол хууль журмууд
- Японы өдөр тутмын дэг журам (олон нийтийн тээвэр, унаа тэрэг, түр байр)
- Хөдөлмөр зохицуулалтын хууль журмууд (Хөдөлмөрийн гэрээ, цуцлах, хөдөлмөрийн цаг, завсарлага, амралт, цалин хөлс зэрэг)
- Нийгмийн даатгал, хөдөлмөрийн даатгал
- Татвар, (орлогын болон иргэний даатгал)
- Ажил мэргэжлийн осол
- Ур чадварын дадлага хийхэд хүндрэлтэй болсон үед Гэрлэх, жирэмслэх болон төрүүлсэн тохиолдолд
- Бүхий л төрлийн зөвлөгөө авах боломж
- Мэдүүлэх тогтолцоо
- GIUCHD-жих системийн ерөнхий агуулга

Японд амьдрахад заавал шаардагдана ! Доорхи зүйлсийг апп дотор ашиглаж боломжтой

• Танд шаардлагатай мэдээллийг манай байгууллагаас уг апп-аар дамжуулан хүргэнэ.

• Эх хэлээрээ зөвлөгөө авах :

Японд амьдрах болон дадлагажих явцад хүндрэл бэрхшээл тулгарсан үед бидэнтэй зөвлөөрэй.

• Гамшгийн талаарх мэдээлэл : газар хөдлөл, салхи шуурга болон усны аюулын тухай мэдээлэлийг цаг алдалгүй тухайн үед нь авах боломжтой

• Албан байгууллага хайх (Элчин сайдын яам) : Танай улсын ЭСЯ-ны мэдээлэл

• Апп-аар дамжуулан хамтран ашиглах боломжтой зүйлс : Facebook, X (хуучин Twitter), LINE, E-мэйл зэргээр дамжуулан бусадтайгаа хуваалцах боломжтой.

• Аппыг ашиглан хувийн мэдээлэл цуглуулахгүй



## ■ Холбогдох байгууллага

Гадаад иргэдийн ур чадварын дадлагажилтын байгууллага (ОТИТ) ур чадвар дадлагажилтын

Удирдамжийг дэмжих хэлтсийн дэмжлэг үзүүлэх хэлтэс Утас:03-6712-1965